



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 0/19


Өвт

**Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай" А/21 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотоос Бат-Өлзий сумын иргэдийг татан авах ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 22-оос 01 дүгээр сарын 27-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллахыг сумын Онцгой комисс (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.
2. Халдвартай бүсээс ирсэн иргэдийг гэрийн хязгаарлалтад 14 хоног байх хугацаанд халдвар, хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хяналт тавих ажлыг эрчимжүүлж, хамтран ажиллахыг сумын Онцгой комисс Н.Бат-Эрдэнэ), Эрүүл мэндийн төвийн дарга (О.Отгонболд), нийгмийн ажилтан (Г.Ганчимэд), багийн Засаг дарга (Т.Жамъянжав, Д.Даваацэрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Л.Балжинням) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Л.Батчулуун), Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад (Д.Энх-Амгалан)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН